



“АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ” ХХК

***БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД
БАЙРЛАХ “АДХИМИ СЕЛИС КЛЕН
ФЕРПЕКТ ХХК”- ИЙН ХИМИЙН БОДИС
ИМПОРТЛОХ, ХУДАЛДААЛАХ
АГУУЛАХЫН ТӨСӨЛ***

**2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5120772

УЛААНБААТАР ХОТ 2025 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч мэдээлэл

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга

1.3 Төслийн зорилго

1.4 Төслийн зорилт

БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.2 Менежментийн төлөвлөгөөний зорилго

2.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

2.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ТӨСЛИЙН НЭР	“ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ, ХАДГАЛАХ”
ТӨСЛИЙН ЗОРИЛГО	Олон улсын чанарын шаардлагад нийцсэн, салбартаа тэргүүлэгч дэлхийн брэндийн бүтээгдэхүүнүүдийг импортлон хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүчний салбарт хэрэглэгдэх чанартай бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах.
ТӨСЛИЙН БАЙРШИЛ	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Интердесижн ХХК-ийн агуулах
ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн импорлох, худалдах, сургалт мэдээлэл зөвлөгөө өгөх.
ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮР ДҮН	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт эрүүл ахуйн чанар стандартыг олон улсын жишигт хүргэхэд өөрийн тус нэмрийг оруулах, уул уурхай, цахилгаан дулааны станцуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай бодис бүтээгдэхүүн нийлүүлэн хамтран ажиллах
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	“Адхими Селис Клен Ферпект” ХХК
ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:	2025 он

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Манай байгууллага АНУ-ын “ECOLAB” компанийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодис бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, уул уурхай, цахилгаан станцууд зэрэг чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэн, сургалт мэдээлэл өгөн хамтран ажиллаж байна.

Манай байгууллагын эрхэм зорилго нь Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг, үйлчилгээний байгууллагууд, хүнсний үйдвэрүүд, сургууль цэцэрлэг, уул уурхайн компаниуд зэрэг газруудад шаардлагатай цэвэрлэгээ, ариутгалын бэлдмэлийг ханган нийлүүлэх, эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар сургалт зохион байгуулах, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах зорилготой.

Одоогоор манай компани хүнсний үйлдвэрүүд эмнэлэг, сургууль, цэцэрлэг, банк, ресторан, бассейн, саун, бар, зочид буудал, хими цэвэрлэгээний газрууд, хувь хүмүүстэй тогтмол харилцаатай ажиллаж байна.

Манай компани Монгол улсын хуулийн хүрээнд:

- "Эрүүл Мэндийн Яам", "Байгаль Орчин Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам", "Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам"-ны сайд нарын хамтарсан "Монгол улсад тухайн онд ашиглаж болох ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт"-нд манай компанийн импортлодог халдваргүйжүүлэлтийн бэлдмэлүүд багтсан.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 26 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар А/73, А/44, А/46 Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад 2025 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, тоо хэмжээг 1 дүгээр, газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт, тоо хэмжээг 2 дугаар, мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, тоо хэмжээг 3 дугаар, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, тоо хэмжээг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/96, А/104, А/81 дугаар хамтарсан тушаалыг хүчингүйд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД
СОДОНТУЯА

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД
Ж.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД
Т.МӨНХСАЙХАН

- "Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам"-ны "Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл"-тэй

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСТАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2025-04-25 Дугаар: 0000163 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ ХХК
Аж ахуйн нэгжийн сэрнэлгээний дугаар: 9011088081
Регистрийн дугаар: 5120772
Хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн бүс
Утас: 99118133, 94188133
Дараах химийн хорт, аюултай бодис: Импортлох, худалдах
2025.04.25-2026.04.25 тусгай зөвшөөрлийг хүргэх хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар/САН	Ашиглах	Үйлдвэрлэсэн үе	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Амьсгалдаг, дараах нь 9 нэр төрөл бодис:						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Алтан-Булаг, Сүхбаатар, Гашуунсүхуйт, Бичигт, Замын-Үүд, Баянхонгор, Чингис хаан
Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам
Төрийн нарийн бичгийн дарга / ЦУРТНАСАН /
Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн / Л.БАТЗОРИГ /

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСТАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2025-04-25 Дугаар: 0000163 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ ХХК
Аж ахуйн нэгжийн сэрнэлгээний дугаар: 9011088081
Регистрийн дугаар: 5120772
Хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн бүс
Утас: 99118133, 94188133
Дараах химийн хорт, аюултай бодис: Импортлох, худалдах
2025.04.25-2026.04.25 тусгай зөвшөөрлийг хүргэх хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар/САН	Ашиглах	Үйлдвэрлэсэн үе	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Амьсгалдаг, дараах нь 9 нэр төрөл бодис:						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Алтан-Булаг, Сүхбаатар, Гашуунсүхуйт, Бичигт, Замын-Үүд, Баянхонгор, Чингис хаан
Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам
Төрийн нарийн бичгийн дарга / ЦУРТНАСАН /
Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн / Л.БАТЗОРИГ /

Бид эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, олон улсын HACCP, GMP, GHP, ISO 9001, ISO 14001 стандартуудыг нэвтрүүлэхэд шаардлагатай зөв дадал хэвшил, хяналтыг бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар зөв мэдлэг мэдээллээр хэрэглэгчдийг хангах зэрэгт анхаарч холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай сургалт зохион байгуулан хамтран ажиллаж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 сарын 24-ний өдрийн А/406 тоот “ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ” тушаалаар батлагдсан хүнсний үйлдвэр болон үйлчилгээний газрын орчны халдвар хамгаалал, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ халдваргүйтгэл, ажилчдын гар ариутгал, хувцас хэрэглэл ариутгал нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд “ECOLAB” компанийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэлүүд, дэлхийн стандартад нийцсэн бодис бүтээгдэхүүнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд

сөрөг нөлөө багатай бодис бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулан ажиллах зорилго тавин ажиллана.

а. ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө багатай бэлдмэл импортлох, борлуулах
- Бүтээгдэхүүний хэрэглээ болон аюулгүй ажиллагааны талаарх сургалт зохион байгуулах
- Дэлхийд шинээр нэвтэрч буй техник технологи, бэлдмэлийг судлах, турших, мэдээллэх, нэвтрүүлэх
- Олон улсын болон Монгол улсын эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагуудтай нарийн нягт уялдаа холбоотой ажиллах, хууль дүрмийг биелүүлэх.

Дээрх зорилтын хүрээнд бид шинэлэг, хүртээмжтэй, хүн амын эрүүл мэнд, хүнсний болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай үйл ажиллагааг өргөжүүлэх, мэдлэг мэдээллээр олон нийтийг хангахад холбогдох төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах болно.

БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болгосон.

Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, аюулгүй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах;
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх;
- Компанийн ажилтнууд, хорооны иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

- Агуулахад хадгалагдаж буй химийн бодист байнгын хяналт тавих, агуулах орчмын агаарын чанар муудсан шинж тэмдэг илэрвэл тухай бүрд нэн даруй мэргэжлийн байгууллагад хандаж шаардлагатай арга хэмжээг авах
- Хурын усыг хуримтлуулж, хуурайшилттай үед зам талбайг услах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах


- Ус хэмнэлттэй ашиглах зөвлөмжийг ажилчдад танилцуулан ус хуримтлуулах сав нэмэлтээр байршуулах төсвийг төлөвлөгөөнд тусгах
- Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд элдэв төрлийн бодис /тээврийн хэрэгслээс тос, тослох материал, ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн хаягдал/ алдахгүй байх, ажилчдад орчны бохирдлын талаар зөвлөмж мэдээлэл өгөх
- Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд элдэв төрлийн бодис /тээврийн хэрэгслээс тос, тослох материал, ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн хаягдал/ алдахгүй байх, ажилчдад орчны бохирдлын талаар зөвлөмж мэдээлэл өгөх
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжиж буй дүүрэг хорооны удирдлагаас санал авч мод тарих, мөн төлөвлөгөөнд тусгасны дагуу 2024 онд 30 ширхэг мод тарихаар төсөвлөсөн байсанг хэрэгжүүлэн монгол хайлаас, шар хуайс зэрэг мод тарьсан.
- Төслийн үйл ажиллагаанаас эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх, аль болох хөрсөн бүрхэвчийг гэмтээхгүй байх талаар өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах сургалтыг тогтмол зохион байгуулах

2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Тус бүр нь 15,000 төгрөгийн үнэ бүхий 80-100см өндөртэй монос мод 55 ширхэг, 120см өндөртэй, тус бүрийн үнэ 4,500 төгрөгийн үнэ бүхий шар хуайс нэрийн нийт 30 ширхэг мод бутыг төсөл хэрэгжиж буй агуулах байрлах Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт тарьсан ба цаашид ирэх оны төлөвлөгөөнд Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд жил бүр үргэлжлүүлэн тарьж ургуулах төлөвлөгөөтэй байна. 2025 онд тарьсан нийт мод бутны ургалт 40 орчим хувьтай ба 1-2 нас бүхий 80-120 см өндөртэй мод бут сонгон авч тариалсны 30 орчим хувь нь ургаагүй, энэ жилийн цаг агаарын орчин нөхцөл, салхи ихтэй, бороо хур бага орсон, усалгаа багадсан гэж үзэж байна. Мод бут тариалсан эхний 3 жилдээ арчилгаа тордолгоо ихээхэн шаардлагатай байдаг тул хөрсөндөө дасан зохицож чадаагүй, усалгаа таараагүй, цаг агаарын нөхцөл байдал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ургалт хүссэн хэмжээнд байгаагүй. БОННУ-нд тусгасны дагуу нийт тариалах модны хэмжээг жил бүр нэмэгдүүлэх зорилт тавин ажиллана.



А.Тарих мод



Б. Тарьсан байдал

2.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

- Одоогоор төслийн байршил болох Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр нь айл өрх багатай, томоохон аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэр төвлөрсөн бүс юм.
- Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд олдсон тохиолдолд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх арга хэмжээг авна.

2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

- Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг өдөр тутамдаа ангилан ялгаж цэвэрлэж байгаа.
- Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид шилжүүлэн хамтран ажилладаг.
- Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээг улирал тутамд хийж байна.
- Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалтыг байгууллагын ажилтан албан хаагчдад тогтмол орж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.
- Манай компани үйл ажиллагаандаа химийн бодис бүтээгдэхүүн хэрэглэдэггүй зөвхөн импортлох, хадгалах үйл ажиллагаа явуулдаг тул харилцагчид нийлүүлсэн барааны хэрэглэж дууссан химийн бодисын хоосон савыг эргүүлэн татан авч химийн аюултай хог хаягдал, сав баглаа боодол устгах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах ажлын хүрээнд Адхими Селис Клен Ферпект ХХК, Элемент ХХК-ийн хооронд байгуулсан № ХБ-25/165 тоот гэрээний дагуу аюултай хог хаягдал устгах үйлдвэрт хүлээлгэн өгч устгуулдаг.



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж

Хаяг: НД, 3-р хороо Бүс нүүр 12610 гудамж 77 тоот Утас: 7707-3790

2025 оны 06 сарын 18 өдөр

Актын дугаар: 25/429

Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: Адхими селис клен ферпект ХХК

Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт

№	Хаягдлын нэр, төрөл	Хэмжээ	Нэгж кг	Аюулын ангилал
1	Химийн бодисын хоосон хуванцар сав	89.4	кг	Аюултай
Нийт		89.4	кг	-

Устгасан аргачлал:

Дээрхи 89.4 кг аюултай хог хаягдлыг "Элемент" ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200°C -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландшафилдэж устгав.

Жич: Устгалд орсон бодисын нэр төрлийн жагсаалт хавсаргав.

Устгал хийсэн

Химийн мэргэжилтэн

Акт хүлээн авсан




/Э.Халиун/

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЭНХБАДРАЛ

БАТЛАВ:
"АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ" ХХК-ийн
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



С.ГЭРЭЛ

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-25/165

2025 оны 09 -р сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас "Элемент" ХХК РД: /2100061/ /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа, нөгөө талаас /цаашид "Захиалагч" гэх/-ыг "Адхими Селис Клен Ферпект" ХХК РД:/5120772/ түүнийг төлөөлж ахлах эрүүл ахуйч албан тушаалтай О.Уранчимэг нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг зориулалтын газарлуу ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.
- 1.2. Дараах баримт бичиг гэрээний салшгүй хэсэг болно.
 - 1.2.1 Аюултай хог хаягдалтай харьцан ажиллаж буй ажилтны мэргэжилийн үнэмлэх, /хүчинтэй хугацаа, цээж зураг, тамга тэмдэг дарагдсаныг тулгах/
 - 1.2.2 Химийн хортой аюултай бодисын хаягдлыг тээвэрлэх, ачих, буулгах, зөөвөрлөх үеийн эрсдэлийн үнэлгээг хийх /Гүйцэтгэгч компанийн Гүйцэтгэх захирлын гарын үсэг, тамга, Ерөнхий болон тус ажлыг хариуцсан инженерүүд, ажилчдын гарын үсгээр баталгаажсан эх хувь

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1. Захиалагч дараах эртэй:
 - 2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
 - 2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
 - 2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.
- 2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
 - 2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба

- Төсөл хэрэгжүүлэх явцад агуулахын үйл ажиллагаанаас өдөр тутам ахуйн хог хаягдал маш бага хэмжээгээр гарах ба төвлөрсөн хогийн цэгт хаядаг.



“Адхими селс клен фернект” ХХК-наас 2025 оны 06 сарын 18-ны өдөр ирсэн аюултай хог хаягдал устгалд оруулж буй байдал. Устгалын актын хавсралт зураг.

Актын дугаар: 25/429



Аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн

Химич: *Халиун* Э. Халиун


2.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

- Төслийн талбайд ил гал гаргаж болохгүйг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах ажлыг шат дараатайгаар хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Химийн бодис алдагдах, асгарах тохиолдолд /Хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, метал юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/ авч нэмэлтээр байршуулна.

- Агуулахад гал түймрийн үед хэрэглэх галын хорыг хангалттай хэмжээгээр байршуулсан, сараа байршуулах ажлыг 2026 оны 3-р улиралд хийхээр төлөвлөж байгаа.
- Агуулахад термометр байршуулсан
- Ажилчдыг ХАБЭА сургалтанд хамруулж дадлагажуулах ажлыг байгууллага дотооддоо байнга зохион байгуулдаг. Мөн холбогдох харьяа яам, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтуудад тогтмол хамрагдаж байна.
- Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан. Сайн чанарын химийн бодисонд тэсвэртэй хамгаалалтын иж бүрэн хувцас хэрэгслээр бүрэн хангасан.
- Ажилчдыг жил бүр эрүүл мэндийн хугацаат үзлэг шинжилгээнд хамруулдаг ба жил бүрийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг дараа оны 3-4 улиралд багтаан хийхээр төлөвлөсөн.

Химийн бодис бага хэмжээгээр асгарч, алдагдсан тохиолдолд химийн бодисонд тэсвэртэй иж бүрэн хамгаалалтын хувцас хэрэгсэл бүхий аюулгүйн хайрцагийг байршуулсан.

ХИМИЙН БОДИС АЛДАГДСАН ТОХИОЛДОЛД
ХЭРЭГЛЭХ ХАМГААЛАХ ИЖ БҮРДЭЛ



ХИМИЙН БОДИС АЛДАГДСАН ТОХИОЛДОЛД
ХЭРЭГЛЭХ ХАМГААЛАХ ИЖ БҮРДЭЛ

